

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АРВАНХОЁРДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны дөрөвдүгээр сарын 07-ны 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 05 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35¹ дугаар зүйлийн 35¹.1.6, Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>Дуламсүрэнгийн Мэндбаярыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалын сайд С.Эрдэнэд санал болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
2	"Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д өөрчлөлт оруулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

		<p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх хэсгээс "Хүний нөөцийн" гэснийг "Шүүхийн захиргааны удирдлагын" гэж өөрчлөх</p> <p>2. Мөн журмын 1.4 дэх хэсгээс "Үндэсний статистикийн хороонд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга", 6.1 дэх хэсгээс "хагас" гэснийг тус тус хасах</p> <p>3. Журамд оруулсан өөрчлөлтийг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөх</p> <p>4. Энэхүү өөрчлөлтийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдэд мэдэгдэхийг Ажлын алба /С.Цэдэндамба/-нд үүрэг болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалтыг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн батлах Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга/Салбар зөвлөлийн дарга/, 2) Шүүхийн хүний нөөцийн газрын дарга, 3) Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, 4) Шүүхийн ёс зүйн хорооны Ажлын

		<p>албаны дарга, 5) Дотоод аудитын албаны дарга, 6) Шүүхийн захиргааны удирдлагын газрын Захиргааны удирдлага хариуцсан ахлах референт 7) Шүүхийн хүний нөөцийн газрын Хүний нөөц хариуцсан ахлах референт /Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга/ 2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг хүчингүй болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн төрийн захиргааны удирдлагын газрын дарга Сүхтөмөрийн Санчирыг 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлийн даргаар томилох</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулж Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 34 дүгээр тогтоолыг хүчингүй болгох</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга С.Санчирт үүрэг болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар</p>

		ТОГТОВ.
--	--	---------

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА